

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

Дугаар 30

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

Монгол Улсын Усны тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу "Монгол-Ус" ТӨҮГ-ын захирлын "Дүгнэлт хүргүүлэх тухай" 2017 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 1/196 тоот, Туул голын сав газрын захиргааны даргын 2017 оны 6 дугаар сарын 30-ний өдрийн А-Ч.8 тоот тушаалаар олгосон ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж Туул голын сав газрын захиргааны Ус ашиглалтыг зохицуулах албаны уул уурхай, эрчим хүчний ус ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн С.Сүхбат, Ус ашиглагчийг төлөөлж Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 5-р хороо, "Оранж плаза" төвийн 903 тоотод байрлах, улсын бүртгэлийн 1411003097 тоот гэрчилгээ, 5073189 тоот регистрийн дугаартай "Илт гоулд" ХХК-ийн захирал Б.Байгалмаа нар ус ашиглах талаар тохиролцож энэхүү гэрээг 2017 оныг дуустал байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. *Ус ашиглах зориулалт:* Тус компанийн MV-000283 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий "Бага Наймганы доод хэсэг"-ийн алтны шороон ордын үйлдвэрлэлийн технологийн хэрэгцээний усыг Туул голоос, ахуйн хэрэгцээний усыг гүний худаас хангана.

2.1.1. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын Сайдын 2014 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн А05 дугаар тушаалаар баталсан "Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын 3.3-т заасны дагуу 2017 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хүлээж авах ажлын хэсэгт Туул голын сав газрын захиргаанаас төлөөлөл оролцуулж, дүгнэх хуудсыг баталгаажуулна.

2.2. *Нийт ашиглах усны хэмжээ:* 110'390 м³ элс угаахад зарцуулах ус 441'590 м³/жил

2.2.1. Унд-ахуйд: 1566 м³/жил

2.2.2. Нөхөн сэлбэлтээр ашиглах усны хэмжээ: 120'320 м³/жил

2.2.3. Биологийн нөхөн сэргээлтэнд ашиглах усны хэмжээ: 400 м³/жил

2.2.4. Зам, талбайн усалгаанд ашиглах усны хэмжээ: 17'856 м³/жил

2.2.5. Үйлдвэрлэлд нийт ашиглах усны хэмжээ: 138'576 м³/жил

2.3. *Усны чанар, найрлага:* 2017 оны 7 дугаар сарын 25, 10 дугаар сарын 05-ны дотор гүний худаг болон хаягдлын нуурнаас усны дээж авч итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэн, шинжилгээний дүнг Туул голын сав газрын захиргаанд ус ашиглалтын тайлангийн хамт ирүүлнэ.

2.4. *Усны эх үүсвэр:*

2.4.1. *Байршил:* Туул голоос 7 км зайд шугам хоолойгоор ус татна. Харин унд, ахуйн хэрэгцээний усыг гүний худаг /MV-004412 талбайд байрлах кемпийн худаг/-аас авч ашиглана. Ахуйн худгийн байршил: N 48° 18' 34.3", E 104° 27' 42.8"

2.4.2. *Барилга байгууламж:* Эргэлтийн сан 63600 м³, тунгаах нуур 12000 м³, 14200 м³ эзлэхүүнтэй. Үерийн хамгаалалтын далангийн өндөр 1.3-1.5 м, урт-400 м.

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

2.4.3. *Тоног төхөөрөмжийн нэр, марк:* Зэрэгцээ байрласан 80 м³/цаг хүчин чадалтай угаах төхөөрөмж ашиглана.

2.4.4. *Насосны хүчин чадал:* Туул голоос 1Д1250-69 маркийн насосоор 159 мм, 4.5 км урт хоолой, нуураас угаах төхөөрөмж рүү Д630/90 маркийн насосоор 159 мм голчтой, 500 м урт ган хоолойгоор ус татаж, алттай элсийг угаана.

2.5. *Хаягдал усны хэмжээ, стандартын шаардлага:* 2017 оны 7 дугаар сарын 25, 10 дугаар сарын 05-ны дотор гүний худаг болон хаягдлын нуурнаас усны дээж авч итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэн, шинжилгээний дүнг Туул голын сав газрын захиргаанд ирүүлнэ.

2.6. *Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ:*

2.7. *Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин:* Технологийн хаягдал усыг тунгаах нууранд тунгааж, эргүүлэн ашиглана.

2.8. *Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:* Усны тухай хуулийн 1 дүгээр бүлгийн 6 дугаар зүйлийн 6.2.3 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор MV-004412 тоот ордын талбайд 2016 оны 6 дугаар сарын 01-ний өдөр газрын доорх усны автомат түвшин хэмжигч суурилуулсан. Газрын доорх усны цооног өрөмдөж, автомат түвшин хэмжигч худалдан авч суурилуулахад нийт 10.8 сая төгрөг зарцуулсан. 2017 оны 7 дугаар сард багтаан хэмжилтийн мэдээг авч, боловсруулалт хийнэ.

2.9. *Усны тоолуур:* Усны тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалт, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А-156 дугаар тушаалаар баталсан “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”-ыг үндэслэн уурхайн ус ашиглалтыг тооцох зорилгоор 2016 онд усны тоолуур суурилуулсан. Хэрэв технологийн усыг нөхөн сэлбэлтээр нэмэлтээр өөр бусад эх үүсвэрээс хангах тохиолдолд заавал мэдэгдэж, усны тоолуур суурилуулна.

2.10. *Ус ашигласны төлбөрийн хэмжээ:*

2.10.1. Урьдчилсан байдлаар нөхөн сэлбэлтээр ашиглах 120'320 м³ усны төлбөрт 28'707'149 /хорин найман сая долоон зуун долоон мянга нэг зуун дөчин ес/ төгрөг, ногоон байгууламжийн усалгаанд ашиглах 400 м³ усны төлбөрт 7'440 /долоон мянга дөрвөн зуун дөч/ төгрөг, зам, талбайн усалгаанд ашиглах 17'856 м³ усны төлбөрт 1'420'088 /нэг сая дөрвөн зуун хорин мянга наян найм/ төгрөг, нийт 30'134'677 /гучин сая нэг зуун гучин дөрвөн мянга зургаан зуун далан долоо/ төгрөгийг Төв аймгийн Төрийн сан банкны 140000944 тоот дансанд төвлөрүүлнэ. Төлбөрийн 20 хувийг хоёрдугаар, 40 хувийг гуравдугаар, 40 хувийг дөрөвдүгээр улиралд төлнө.

2.10.2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт заасны дагуу усны төлбөрийг төвлөрүүлэхдээ тоолуурын заалтыг үндэслэн ус ашиглуулах дүгнэлтээр тогтоосон төлбөрийн хувь хэмжээгээр тооцож, орлогыг дараа сарын 10-ны өдрийн дотор төлж барагдуулах бөгөөд усны тоолуур суурилуулахаас өмнөх ус ашиглалтын хэмжээг уулын ажлын тайланг үндэслэн Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн А/301 тоот тушаалаар баталсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ын дагуу тооцно.

Гурав. Талуудын эрх, үүрэг

3.1. Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

3.2. Ус ашиглагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Усны тухай хуулийн 17.1.9, 29.3 дугаар заалтуудыг үндэслэн Сав газрын захиргааны шийдвэрээр гэрээг

хугацаанаас нь өмнө цуцлах бөгөөд Усны тухай хуулийн 33.1.10, 33.1.12, 33.1.13, 33.1.14, 33.1.15, 33.1.16 дахь заалтын дагуу хариуцлага хүлээнэ.

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Ус ашиглуулагч нь 2017 оны 12 дугаар сарын 20-ны дотор ус ашиглалтын тайланг хүлээн авч, 2 тал гэрээний биелэлтийг ажлын 14 хоногт багтаан дүгнэж, тэмдэглэл үйлдэн гарын үсэг зурж баталгаажуулна.


4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба өөрчлөлтийг бичгээр үйлдэнэ.

4.5. Талуудын хооронд үүссэн маргааныг зөвшилцөлийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд гэрээ болон түүний аль нэг заалттай холбоотой асуудлаар зөвшилцөлд хүрч чадаагүй тохиолдолд асуудлыг холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.


ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААГ
ТӨЛӨӨЛЖ:

Ус ашиглалтыг зохицуулах албаны
дарга

 /Ю.Сувдчимэг/

Мэдээлэл, хяналт үнэлгээний албаны
дарга

 /Б.Оюунболд/

Ус ашиглалтыг зохицуулах албаны уул
уурхай, эрчим хүчний ус ашиглалт
хариуцсан ахлах мэргэжилтэн

 /С.Сүхбат/

“ИЛТ ГОУЛД” ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Маркшейдер инженер

 /М.Алтангэрэл/

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй
дүүргийн 5-р хороо, “Оранж плаза”
төвийн 903 тоот
Харилцах утас: 99110900, 99040209

Хаяг: Улаанбаатар хот-16050, БГД,
2-р хороо, Чингүнжавын гудамж,
Туул голын сав газрын захиргааны
байр, 2 дугаар давхар, 203 тоот өрөө
Харилцах утас: 363716, 363714, 362592